



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ДАРХАНЫ ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ ТӨХК 2021 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/99/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор  
Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)  
Аудитын менежер: Ц.Хосжаргал  
Утас: 261885 Цахим хаяг: [khosjargalts@audit.gov.mn](mailto:khosjargalts@audit.gov.mn)  
Аудитор: Э.Бүгүнүтэй  
Утас: 261885 Цахим хаяг: [bugunuteie@audit.gov.mn](mailto:bugunuteie@audit.gov.mn)  
Аудитын гэрээгээр гүйцэтгэсэн: Эвиденсе Аудит ХХК-ийн  
Захирал С.Бадамгарав  
Утас: 70007121 Цахим хаяг: [info@evidenceaudit.mn](mailto:info@evidenceaudit.mn)

Улаанбаатар хот  
2022 он

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт .....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан .....	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	6
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....	7
3. Аудитын тайлан .....	8
3.1 Ерөнхий зүйл .....	8
3.2 Дотоод хяналт .....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	8
3.4 Материаллаг байдал .....	9
4. Санхүүгийн тайлангийн тодруулга .....	9
4.1 Байгууллагын үйл ажиллагаа .....	9
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин .....	9
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого .....	10
4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....	11
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	11
5.1 Шилэн дансны мэдээлэл .....	11
5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд .....	12
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	12
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	12
8. Аудитын илрүүлэлт .....	13
8.1 Албан шаардлага .....	13
8.2 Зөвлөмж .....	13
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	15

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ДАРХАНЫ ДУЛААНЫ ЦАХИЛГААН  
СТАНЦ ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ М.ЖАРГАЛСАЙХАН  
ТАНАА

2022.03.15 № 07/603  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

Хараат бус аудиторын тайлан

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дарханы Дулааны Цахилгаан Станц ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Дарханы Дулааны Цахилгаан Станц ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 527.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч тогтоосон материаллаг түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, иж бүрэн байх, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Эрчим хүчний сайдын 2021 оны 08 дугаар сарын 03-ний өдөр А/142 дугаар тушаалаар 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нийт орлогыг 57,275.2 сая төгрөгөөр, нийт зардлыг 61,431.6 сая төгрөгөөр, алдагдлыг 4,156.4 сая төгрөгийн байхаар баталсан байна.

Эрчим хүчний сайдын 2021 оны А/10 дугаар тушаалаар нийт орлогыг 1,638.7 сая төгрөгөөр, нийт зардлыг 1,638.7 сая төгрөгөөр тус тус бууруулж тодотгосон байна. Гүйцэтгэлээр 62,069.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 59,697.1 сая төгрөгийн зардал гарган, 2,372.6 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

### **Бусад мэдээлэл**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Компанийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 12 зорилтын хүрээнд 42 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэл 100.0 хувьтай гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

<i>/төгрөгөөр/</i>			
№	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	<b>ХӨРӨНГӨ</b>		
1.1	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	25,280,313.32	196,603,394.52
1.1.2	Дансны авлага	3,859,408,472.85	6,118,603,971.26
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	379,910,378.24	405,422,444.28
1.1.4	Бусад авлага	205,501,492.83	203,787,126.58
1.1.6	Бараа материал	4,238,347,308.92	3,593,931,850.05
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	517,834,757.36	562,136,551.23
1.1.20	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>9,226,282,723.52</b>	<b>11,080,485,337.92</b>
1.2	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	150,497,353,716.65	145,629,531,329.04
1.2.2	Биет бус хөрөнгө	25,167,298,677.53	24,883,347,937.87
1.2.20	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>175,664,652,394.18</b>	<b>170,512,879,266.91</b>
1.3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>184,890,935,117.70</b>	<b>181,593,364,604.83</b>
2	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
2.1	<b>ӨР ТӨЛБӨР</b>		
2.1.1	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	3,971,610,657.43	3,845,292,536.14
2.1.1.2	Цалингийн өглөг	393,452,976.00	376,653,856.00
2.1.1.3	Татварын өр	1,266,691,497.91	1,288,443,854.17
2.1.1.4	НДШ-ийн өглөг	1,183,743,129.14	852,278,486.36
2.1.1.5	Богино хугацаат зээл	1,230,240,046.00	835,862,778.07
2.1.1.8	Хойшлогдсон орлого	190,806,603.20	594,421,970.20
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	12,226,151.17	9,844,725.38
2.1.1.20	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>8,248,771,060.85</b>	<b>7,802,798,206.32</b>
2.1.2	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл	74,269,170,834.92	69,796,045,609.02
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	13,234,489,635.60	12,483,947,125.35
2.1.2.20	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>87,503,660,470.52</b>	<b>82,279,992,734.37</b>
2.2	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>95,752,431,531.37</b>	<b>90,082,790,940.69</b>
2.3	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Төрийн өмч	32,643,240,005.47	10,040,100,005.47
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	72,035,560,054.37	72,035,033,589.81
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	-	22,603,140,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(15,540,296,473.51)	(13,167,699,931.14)
2.3.20	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>89,138,503,586.33</b>	<b>91,510,573,664.14</b>
2.4	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>184,890,935,117.70</b>	<b>181,593,364,604.83</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	<b>Борлуулалтын орлого ( цэвэр )</b>	<b>47,201,663,485.7</b>	<b>50,808,096,868.2</b>
2	Борлуулалтын өртөг	47,181,347,648.7	50,841,127,519.0
3	<b>Нийт ашиг ( алдагдал )</b>	<b>20,315,837.0</b>	<b>(33,030,650.8)</b>
5	Хүүгийн орлого	2,731,411.3	74,666.3
8	Бусад орлого	3,524,394,150.7	1,437,713,182.0
10	Ерөнхий ба удирдлагын зардал	315,667,687.6	999,876,869.4
11	Санхүүгийн зардал	-	199,191,020.6
12	Бусад зардал	6,367,095,485.4	3,410,215,190.7
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз ( гарз )	(8,553,393,970.8)	5,573,198,911.8
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	77,912,668.3	3,930,980.5
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>(11,610,803,076.5)</b>	<b>2,372,604,009.0</b>
19	Орлогын татварын зардал	273,152.3	7,466.6
20	<b>Татварын дараах ашиг ( алдагдал )</b>	<b>(11,611,076,228.8)</b>	<b>2,372,596,542.4</b>
21	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг ( алдагдал )</b>	-	-
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>(11,611,076,228.8)</b>	<b>2,372,596,542.4</b>
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз ( гарз )	-	-
24	<b>Орлогын нийт дүн</b>	<b>(11,611,076,228.8)</b>	<b>2,372,596,542.4</b>
25	<b>Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)</b>	-	-

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл		72,108,109,086.29	-	(3,923,190,244.73)	100,889,686,901.54
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		-	-	-	-
Залруулсан үлдэгдэл		72,108,109,086.29	-	(3,923,190,244.73)	100,89,686,901.54
Бусад дэлгэрэнгүй орлого		(72,549,031.92)	-	-	(72,549,031.92)
Өмчид гаргасан өөрчлөлт		-	-	-	(61,528,054.51)
Зарласан ногдол ашиг		-	-	(6,030,000.00)	(6,030,000.00)
Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )		-	-	(11,611,076,228.78)	(11,611,076,228.78)
<b>2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>		<b>72,035,560,054.37</b>	-	<b>(15,540,296,473.51)</b>	<b>89,138,503,586.33</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		-	-	-	-

Дарханы дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд  
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Залруулсан үлдэгдэл		72,035,560,054.37	-	(15,540,296,473.51)	89,138,503,586.33
Өмчид гаргасан өөрчлөлт		-	22,603,140,000.00	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )		-	-	2,372,596,542.37	2,372,596,542.37
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		(526,464.56)	-	-	(526,464.56)
<b>2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>		<b>72,035,033,589.81</b>	<b>22,603,140,000.00</b>	<b>(13,167,699,931.14)</b>	<b>91,510,573,664.14</b>

#### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

		<i>/төгрөгөөр/</i>	
№	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>43,919,676,650.65</b>	<b>45,081,948,629.44</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	43,583,319,951.93	44,770,811,096.01
1.1.6	Бусад мөнгөн орлого	336,356,698.72	311,137,533.43
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>43,406,835,251.18</b>	<b>44,469,248,882.17</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	10,103,630,472.52	10,615,701,720.05
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	2,316,590,000.00	3,753,100,001.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	11,511,016,784.47	13,088,453,270.47
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	16,870,556,298.75	14,346,123,000.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	110,647,451.38	215,404,236.83
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	2,407,878,414.54	2,442,343,678.46
1.2.9	Бусад мөнгөн зарлага	86,515,829.52	8,122,975.36
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>512,841,399.47</b>	<b>612,699,747.27</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>2,731,411.30</b>	<b>74,666.30</b>
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	2,731,411.30	74,666.30
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>1,522,452,648.00</b>	<b>1,038,649,601.30</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,522,452,648.00	1,038,649,601.30
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(1,519,721,236.70)</b>	<b>(1,038,574,935.00)</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>6,106,886,925.20</b>	<b>7,649,190,959.24</b>
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	6,105,988,245.00	7,649,146,238.61
3.1.4	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	898,680.20	44,720.63
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>5,278,480,253.37</b>	<b>7,051,992,690.31</b>
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	5,275,764,459.50	7,036,862,543.81
3.2.5	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	2,715,793.87	15,130,146.50
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>828,406,671.83</b>	<b>597,198,268.93</b>
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(178,473,165.40)</b>	<b>171,323,081.20</b>
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	203,753,478.72	25,280,313.32
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	25,280,313.32	196,603,394.52

## 2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Х.нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
0	2	3		4	5	6	7
1	Боловсруулах /ЦЭХ/	Сая. квтц	346.8	308.3	332.2	23.9	108.0
	ДХЦЭХ/ДЭХ/	мян Гкал	582.7	586.0	592.7	6.7	101.0
	Түгээх/хувиар/	%	15.7	16.5	15.5	(1.01)	94.0
2	Нийт орлого	сая төг	55,563.7	57,275.2	62,069.7	4,794.5	108.0
	Үүнээс: Борлуулалтын орлого	Гкал	47,201.7	46,296.1	50,808.1	4,512.0	110.0
	Үйл ажиллагааны бус	Сая төг	8,362.0	10,979.1	11,261.6	282.5	103.0
3	Нийт зардал	Сая төг	67,174.8	61,431.6	59,697.1	(1,734.5)	97.0
	Үүнээс: Үйл ажиллагааны	Сая төг	52,656.1	52,354.3	54,249.1	1,894.8	104.0
	Үйл ажиллагааны бус зардал	Сая төг	14,518.6	9,077.2	5,448.0	(3,629.2)	60.0
4	Татварын өмнөх ашиг/алдагдал/	Сая төг	(11,611.1)	(4,156.4)	2,372.6	6,529.0	(57.0)
5	Татварын дараах ашиг/алдагдал/	Сая төг	(11,611.1)	(4,156.4)	2,372.6	6,529.0	(57.0)
6	Борлуулалтын орлогын 1 төгрөгт	сая төг	1.1	1.1	1.0	(0.1)	94.0
7	Нийт авлага	Сая төг	4,444.8	3,919.8	6,727.3	2,807.5	172.0
	Үүнээс: ЭХ-ний	Сая төг	3,859.4	3,522.7	6,118.6	2,595.9	174.0
	Бусад	Сая төг	585.4	397.1	608.7	211.6	153.0
8	Нийт өглөг	Сая төг	82,327.2	92,187.2	90,082.3	(2,104.9)	98.0
	Үүнээс: УХӨТ	Сая төг	74,269.2	85,229.9	82,280.0	(2,949.9)	97.0
	БХӨТ	Сая төг	8,058.0	6,957.3	7,802.3	845.0	11.0
9	Нийт ажиллагчдын тоо	хүн	485.0	485.0	485.0	-	100.0
10	Нийт цалингийн сан	сая төг	12,758.4	12,469.3	12,453.2	(16.2)	100.0
11	Жишмэл түлшний ЦЭХ	гр/квтц	425.1	433.6	432.9	(0.7)	100.0
	ДЭХ	кг/Гкал	185.7	190.1	189.8	(0.3)	100.0
12	Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө	сая төг	6,071.1	6,655.1	6,215.0	(440.1)	93.0



### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дарханы Дулааны Цахилгаан Станц ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад төлбөрийн цахим баримтгүй ажил гүйлгээ, ТБОНӨБАҮХАТухай хуулийг мөрдөн ажиллаагүй тендерийн үнэлгээний хорооны худалдан авах ажиллагаа, үл хөдлөх хөрөнгийн даатгалыг буруу тооцон төлсөн, ангилал буруу бүртгэсэн, элэгдэл буруу тооцсон зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 02 дүгээр сарын 15-аас 2022 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Эвиденсе аудит ХХК-ийн ахлах аудитор С.Оюундэлгэр, Д.Шүрэнцэцэг, аудитор Д.Мөнхжаргал, Т.Болортуяа, аудиторын туслах Э.Билгүүн, Э.Энхжил нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Б.Пушкин, захирал С.Бадамгарав нар тус тус хэрэгжүүлсэн.

Дарханы Дулааны Цахилгаан Станц ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 1/171 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант оны эхний хагас жилийн эргэлтийн хөрөнгийн тооллогыг албаны даргын 2021 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А-105 тоот тушаалаар, жилийн эцсийн үндсэн хөрөнгө, эргэлтийн хөрөнгийн тооллогыг албаны даргын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн А/119 тоот тушаалын дагуу хийж гүйцэтгэсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Дарханы Дулааны Цахилгаан Станц ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн ерөнхий ба удирдлагын зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2020 оны ерөнхий ба удирдлагын зардал 1,659.1 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 16.6 сая төгрөгөөр тогтоосон ба төлөвлөлтийн үе шатны ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатны үед дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## **4. Санхүүгийн тайлангийн тодруулга**

### **4.1 Байгууллагын үйл ажиллагаа**

Дарханы Дулааны Цахилгаан Станц ТӨХК нь цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэх, зуух, даралтад сав, шугам хоолойн угсралт засвар, зуух даралтат сав, шугам хоолойн хийц хэсгүүдийн үйлдвэрлэл, гадаад худалдаа эрхлэх үйл ажиллагаа явуулдаг, Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг зуухны угсралт, засвар, шугам хоолойн угсралт засвар, зуух даралтад сав, шугам хоолойн хийц хэсгүүдийн үйлдвэрлэл, гадаад худалдаа гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд төрийн өмчит хувьцаат компани гэсэн статустай байна. Өмчийн 100.0 хувийг төр, үүнээс Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар 30.0 хувь, Эрчим хүчний яам 70.0 хувийг эзэмшиж байна.

### **4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин**

Дарханы Дулааны Цахилгаан Станц ТӨХК-ний Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг сард 0.7 сая төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалтай нийцэж байна.

Дарханы дулааны цахилгаан станц нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;”-д заасны тус тогтоолыг мөрдөн ажиллаж өмнөх оноос орон тоогоо таваар багасгаж, цалин хөлсийг орлого, үр ашигтай уяалдуулан, шагнал урамжуулал олгоогүй, бэлэг дурсгалын зардал гаргаагүй байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоол

#### 4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Дарханы Дулааны Цахилгаан Станц ТӨХК-ийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	25,280.3	196,603.3	171,323.1
Дансны авлага	3,859,408.4	6,118,603.9	2,259,195.5
Татвар, НДШ-ийн авлага	379,910.3	405,422.4	25,512.1
Бусад авлага	205,501.4	203,787.1	(1,714.4)
Урьдчилгаа	517,834.7	562,136.5	44,301.7
Бараа материал	4,238,347.3	3,593,931.8	(644,415.4)
Үндсэн хөрөнгө	150,497,353.7	145,629,531.3	(4,867,822.4)
Биет бус хөрөнгө	25,167,298.6	24,883,347.9	(283,950.7)
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>283,950.7</b>	<b>283,950.7</b>	<b>(3,297,570.5)</b>
Өр төлбөрийн дүн			
Богино хугацаат өглөг	8,248,771.1	7,802,798.2	(445,972.8)
Урт хугацаат өглөг	87,503,660.4	82,279,992.7	(5,223,667.7)
Эздийн өмч	89,138,503.6	91,510,573.7	2,372,070.1
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>184,890,935.1</b>	<b>181,593,364.6</b>	<b>(3,297,570.5)</b>

Касс дахь бэлэн мөнгө 8.5 сая төгрөг, банк дахь харилцах дансанд 188.1 сая төгрөг байна.

Тайлант онд цахилгаан эрчим хүч хуваарилах үйл ажиллагааны хүрээнд үүссэн Диспетчерийн үндэсний төв ХХК-аас авах авлага 5,807.7 сая болж нэмэгдсэн нь авлагын өсөлтөд голлон нөлөөлжээ. Татвар, НДШ-ийн авлага 405.4 сая төгрөг байна.

Урьдчилж төлсөн тооцоо данс 44.3 сая төгрөгөөр өссөн нь бэлтгэн нийлүүлэгчид төлсөн шарын гол ХК, Багануур ХК-ийн нүүрсний урьдчилгаа төлбөр 38.8 сая төгрөг, Замд яваа нүүрсний тээврийн зардал 5.5 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд 1,879.5 сая төгрөгийн сэлбэг материал буюу 52.0 хувь, 887.3 сая төгрөгийн нүүрс буюу 25.0 хувь, 366.8 сая төгрөгийн мазут буюу 10.0 хувь, бусад материал 460.3 сая төгрөгийн буюу 13.0 хувийг эзэлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл худалдаж авсан 1,104.3 сая, өөрөө үйлдвэрлэсэн 3,642.8 сая, балансаас баланст хүлээн авсан 6,859.2 сая төгрөгийн хөрөнгөөр тус тус нэмэгдэж, ТӨБЗГ-ын 2021 оны 172 дугаар тогтоолоор дуудлага худалдаагаар худалдсан 48.6 сая төгрөг, 2021 оны 186 дугаар тогтоолоор акталсан 198.9 сая, 2020 оны 440-р тогтоолоор балансаас баланст шилжүүлсэн 4,663.9 сая төгрөгөөр хасагджээ.

Биет бус хөрөнгө данс худалдан авсан 81.8 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд байгуулсан 365.7 сая төгрөгийн хорогдлоор буурсан байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 7,802.8 сая төгрөг нь нүүрсний өглөгийн 1,722.7 сая төгрөг, байгууллагад төлөх өр 2,122.6 сая төгрөг, цалингийн өглөг 376.7 сая төгрөг, татварын өглөгийн 1,288.4 сая төгрөг, нийгмийн даатгалын өглөг 852.3 сая төгрөг,

Хаан банкны зээл 835.8 сая төгрөг, хойшлогдсон орлого 594.4 сая төгрөг, үйлдвэрлэлийн эвлэлийн хороонд өглөг 9.8 сая төгрөгөөс тус тус бүрдэж байна.

Урт хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд Турбин-5 төсөл, Дархан төсөл-1, 2, Эрчим хүчний хөтөлбөр-1 төсөл, эрчим хүчний хэмнэлтийн өглөг, Турбин-5 төслийн зээлийн хүү зэргээс шалтгаалан үүссэн 69,796.0 сая төгрөгийн зээл байна. Урт хугацаат зээлийн эргэн төлөлт хуваарийн дагуу хэвийн төлөгдөж байна.

#### **4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Дарханы Дулааны Цахилгаан Станц ТӨХК нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрчим Хүчний сайдын 2021 оны 08-р сарын 03-ний өдөр А/142 дугаар тушаалаар Дарханы Дулааны Цахилгаан Станц ТӨХК -ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 57,275.2 сая төгрөгөөр, нийт зардлыг 61,431.6 сая төгрөгөөр, 4,156.4 сая төгрөгийн алдагдалтай байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 6,655.1 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Эрчим хүчний сайдын 2021 оны А/10 дугаар тушаалаар нийт орлогыг 1,638.7 сая төгрөгөөр бууруулж, борлуулсан бүтээгдэхүүний өртгийг 1,638.7 сая төгрөгөөр бууруулж тодотгосон байна.

Гүйцэтгэлээр 62,069.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 59,697.1 сая төгрөгийн зардал гарган, 2,372.6 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 62,069.7 сая төгрөг болж төлөвлөснөөс 479.1 сая төгрөг буюу 8 хувиар давсан нь гүйлгээгээр гарсан гадаад валютын ханшийн зөрүүнээс голчлон шалтгаалсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 59,697.1 сая төгрөг болж, төлөвлөснөөс 1,734.5 сая төгрөг буюу 3 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь Ковид-19 цар тахалтай холбоотойгоор бусад зардалд зарцуулах мөнгө буурсан, түүхий эд материал дахь нүүрсний үнийн бууралт нөлөөлсөн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 44 нэр төрлийн 44 ажилд өөрийн эх үүсвэрээс 100% буюу 6,215.0 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг 2,372.6 сая төгрөг болж, төлөвлөснөөс 6,528.9 сая төгрөгөөр илүү байгаа нь гадаад валютын ханшийн зөрүүний олз болон түүхий эд материал дахь нүүрсний үнийн бууралт нөлөөлсөн байна.

#### **5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

##### **5.1 Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 27 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дарханы дулааны цахилгаан станц нь нийт 33,272.1 сая төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 33,272.1 сая төгрөгийн 151 мэдээллийг байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална" 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх" 4.1.2 "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалттай нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангасан байна.

## **5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Компанийн 2021 оны ХАА-ны төлөвлөгөөнд тусгагдан зарласан 443.2 сая төгрөгийн тендерүүдэд оролцож шалгарсан ЗОЗА ХХК, Эрчим маш ХХК, ГКАЛ ХХК-үүдийн ирүүлсэн тендерийн материалд хавсаргасан санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд буруу байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх" зарчмын заалттай нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: "Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, бүтээгдэхүүн худалдан авах тухай хууль", "Босго үнэ шинэчлэн батлах тухай" Засгийн газрын тогтоолыг тус тус мөрдөж ажиллах, цаашид тендерийн үнэлгээний хороо эрх, үүргийн дагуу ажлаа зөв оновчтой зохион байгуулах зөвлөмж хүргүүлэх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, сэлбэг хэрэгслийн худалдан авалт нь Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, бүтээгдэхүүн худалдан авах тухай хууль, Босго үнэ шинэчлэн батлах тухай 2021 оны Засгийн газрын 124 дугаар тогтоолтой тус тус нийцээгүй байна гэж дүгнэлээ.

## **6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1,941.3 сая төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

## **7. Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дарханы дулааны цахилгаан станц ТӨХК-ийн үндсэн хөрөнгийг байгууллага дээр очиж биетээр тоолж, санхүүгийн бүртгэлтэй тулган шалгах явцад үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ хийх шаардлагатай гэж дүгнэлээ.

Ажилчдын цалингаас утасны төлбөрийн суутган тооцоолол хийж байгаа нь төрийн чиг үүрэгт байхгүй үйлчилгээг үзүүлж, төрийн ажиллах хүчний зардал болон бусад үр ашиггүй зардлууд гарган оновчтой зохистой удирдлагаар хангаж ажиллаагүй.

Сарын үр дүн, жилийн үр дүн урамшуулал, балансын шагнал, салбарын тэргүүний ажилтны шагнал зэрэг шагнал, урамшууллыг давхардуулан олгож байгаа нь үр ашигтай, хариуцлагатай байх зарчимд нийцээгүй байна.

Иймээс дараагийн аудитаар дээрх асуудлуудыг нарийвчилсан авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 527.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 74.5 сая төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 452.9 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 527.4 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 16.6 сая төгрөгийн материаллагийн түвшнээс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

### 8.1 Албан шаардлага

Тайлант онд худалдан авсан бараа, ажил үйлчилгээний төлбөрийг гүйцэтгэхдээ 74.5 сая төгрөгийн цахим төлбөрийн и-баримтыг бүрдүүлээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно". Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2."бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно"; 17.6."Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авалтын ажил гүйлгээний төлбөрийн цахим баримтыг бэлтгэн нийлүүлэгчээс бүрэн гаргуулах авах, татварын цахим системээр худалдан авалтыг тухай бүрэн хянаж ажиллах, албан шаардлага хүргүүлэх

### 8.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1.1 Илрүүлэлт:

Компани үл хөдлөх хөрөнгийн татварыг барилга байгууламжийн дансны дүнгээс 0.7 хувиар тооцоолон 295.6 сая төгрөг илүү төлсөн байна. Энэ нь 2000 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн “Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай” хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 *Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар ногдуулах үнэлгээг уул хөрөнгийн үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд бүртгээгдсэн үнийн дүнгээр, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд бүртгээгдээгүй бол хөрөнгийн даатгалд даатгуулсан үнийн дүнгээр, хөрөнгийн даатгалд даатгуулаагүй бол данс бүртгэлд бүртгээгдсэн үнийн дүнгээр тус тус тодорхойлно., гэсэн* заалттай нийцээгүй.

#### 1.2 Өгсөн зөвлөмж:

Татварын байгууллагад хүсэлт гарган үл хөдлөх эд хөрөнгийн тайланг залруулан гаргаж, 2022 онд нөхөн тооцох, бүх барилгын үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ гаргуулах, дахин үнэлсэн хэсгийг салган татварын зориулалтаар үл хөдлөх хөрөнгийн тайланг гаргах

#### 2.1 Илрүүлэлт:

Компани 4599 ш 1 жил ашиглах навчит модыг 2019 онд 42.6 сая төгрөгөөр дахин үнэлж үндсэн хөрөнгө дансанд бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө: 4.1.1 *Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт, -ын дагуу* мөрдөнө гэсэн заалттай нийцээгүй. Эдгээр 4599 ш навчит модыг НББОУС 16-н дагуу үндсэн хөрөнгө дансанд буруу ангилан бүртгэсэн байна.

#### 2.2 Өгсөн зөвлөмж:

НББОУС 41-д заасны дагуу эдгээрийг орлогоор бүртгэн нягтлан бодох бүртгэлд тусгах

#### 3.1 Илрүүлэлт:

Компани 385 ш удирдлагын ажилтнуудын ашиглаж байгаа 114.7 сая үндсэн хөрөнгийн элэгдлийг борлуулсан бүтээгдэхүүний өртөгт бичилт хийсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн, 20.2-т ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээн: *20.2.9 аж ахуйн нэгж, байгууллын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийн цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах* гэсэн заалттай нийцээгүй. Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, цаашид удирдлагын баг алдаатай буруу шийдвэр гаргахад нөлөөлнө.

### **3.2 Өгсөн зөвлөмж:**

Цаашид элэгдлийн зардлыг ерөнхий удирдлагын зардалд оруулан тооцож НББОУС-1, тодруулга ба толилуулга батламж мэдэгдлийн дагуу ерөнхий удирдлагын зардлыг үнэн зөв бүртгэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/ д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
							Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар																
1	ДДЦС	АХГ-2022/99/НА-СТА-ТӨА	Тайлант хугацаанд бараа ажил үйлчилгээний төлбөрийг гүйцэтгэхдээ цахим и-баримтыг бүрдүүлээгүй.	Худалдан авалтын ажил гүйлгээний төлбөрийн цахим баримтыг бэлтгэн нийлүүлэгчээс бүрэн гаргуулах авах, татварын цахим системээр худалдан авалтыг тухай бүрэн хянаж ажиллах	1	74,470.3					1	74,470.3				
2	ДДЦС	АХГ-2022/99/НА-СТА-ТӨА	Компани үл хөдлөх хөрөнгийн татварыг барилга байгууламжийн дансны дүнгээс 0.7 хувиар тооцоолон илүү төлсөн байна.	Татварын байгууллагад хүсэлт гарган үл хөдлөх эд хөрөнгийн тайланг залруулан гаргаж, 2022 онд нөхөн тооцох, бүх барилгын үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ гаргуулах, дахин үнэлсэн хэсгийг салган татварын зориулалтаар үл хөдлөх хөрөнгийн тайланг гаргах	1	295,645.2							1	295,645.2		
3	ДДЦС	АХГ-2022/99/НА-СТА-ТӨА	Компани 4599 ш 1 жил ашиглах навчит модыг 2019 онд дахин үнэлж бүртгэсэн байна.	НББОУС- 16-д заасны дагуу үндсэн хөрөнгө дансанд ангилал буруу бүртгэсэн, НББОУС 41-н дагуу орлогоор бүртгэн нягтлан бодох бүртгэлд тусгах	1	42,597.3							1	42,597.3		
4	ДДЦС	АХГ-2022/99/НА-СТА-ТӨА	Борлуулсан бүтээгдэхүүний өртөгт удирдлагын ажилтнуудын ашиглаж байгаа үндсэн хөрөнгийн элэгдлийг шингээсэн байна.	Цаашид элэгдлийн зардлыг ерөнхий удирдлагын зардалд оруулан тооцож НББОУС-1, тодруулга ба толилуулга батламж мэдэгдлийн дагуу ерөнхий удирдлагын зардлыг үнэн зөв бүртгэх	1	114,688.0							1	114,688.0		
Дүн					<b>4</b>	<b>527,400.8</b>					<b>1</b>	<b>74,470.3</b>		<b>3</b>	<b>452,930.5</b>	



**Дарханы дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд  
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал														
5	ДДЦС	АХГ-2022/99/НА-СТА-ТӨА	ХАА-ны төлөвлөгөөнд тусгагдаж, зарласан тендерүүдэд оролцож шалгарсан ЗОЗА ХХК, Эрчим маш ХХК, ГКАЛ ХХК-ууд ирүүлсэн тендерийн материалд санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд буруу тусгаж ирүүлсэн байна.	“Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, бүтээгдэхүүн худалдан авах тухай хууль”, “Босго үнэ шинэчлэн батлах тухай” Засгийн газрын тогтоолыг тус тус мөрдөн ажиллах, цаашид тендерийн үнэлгээний хороо эрх, үүргийн дагуу ажлаа зөв оновчтой зохион байгуулах	1	443,233.0					1	443,233.0		
<b>Дүн</b>					<b>1</b>	<b>443,233.0</b>					<b>1</b>	<b>443,233.0</b>		
<b>Нийт дүн</b>					<b>5</b>	<b>970,633.8</b>					<b>2</b>	<b>517,703.3</b>		<b>3</b> <b>452,930.5</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 514/А0150055  
АХГ-2022/99/НА-СТАБ-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Дарханы дулаан цахилгаан станц ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд 74,470,295.00 төгрөгийн бараа, ажил, үйлчилгээний төлбөрийг гүйцэтгэхдээ цахим и-баримтыг бүрдүүлээгүй.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 13.4 Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Маягт, заавар батлах тухай" тушаал, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2 "бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно" гэсэн заалттай нийцээгүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2 1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авалтын ажил, гүйлгээний төлбөрийн цахим баримтыг бэлтгэн нийлүүлэгчээс бүрэн гаргуулан авах, татварын цахим системээр худалдан авалт, борлуулалтыг тухай бүрэн хянаж, бүртгэн ажиллах, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлнэ үү.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтах гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дарханы дулааны цахилгаан станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал М.Жаргалсайхан, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Ц.Ууганбаяр нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ЭВИДЕНСЕ АУДИТ  
ХХК-ИЙН ЗАХИРАЛ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Ц.ХОСЖАРГАЛ  
С.БАДАМГАРАВ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 515/АО150655

Улаанбаатар хот

АХГ-2022/99/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Дарханы дулаан цахилгаан станц ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан 443,233,000.00 төгрөгийн тендерүүдэд оролцож шалгарсан ЗОЗА ХХК, Эрчим маш ХХК, ГКАЛ ХХК-үүдийн ирүүлсэн тендерийн материалд санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг буруу тусгаж ирүүлсэн байна.


Энэ нь "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах" тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмын заалттай нийцээгүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Тендерийн баримт бичигт хавсаргасан санхүүгийн тайланг татварын цахим систем дэх балансын үзүүлэлттэй тулгаж байх, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлнэ үү.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтах гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дарханы дулааны цахилгаан станц ТӨХК-н гүйцэтгэх захирал М.Жаргалсайхан, санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Ц.Ууганбаяр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ЭВИДЕНСЕ АУДИТ  
ХХК-ИЙН ЗАХИРАЛ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Ц.ХОСЖАРГАЛ

С.БАДАМГАРАВ



## ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing, consisting of 25 rows.